

# Шинэ Гэрээний төгс эзэмших сургаал: 1-р үнэлгээний шалгалт

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

## Төгс эзэмших сургаалын эшлэл

1–3-р асуултын хувьд, үг хэллэг тус бүрийн хажуу дахь хоосон зайд холбогдох эшлэлийн үсгийг бич. Үнэлгээний шалгалтын энэ хэсэгт судраа ашиглаж болохгүй.

- |  |                   |
|--|-------------------|
| 1. ____ “Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр Бурханы хаанчлалд орж үл чадна.”                | а. Матай 11:28–30 |
| 2. ____ “Намайг дурсаж” ариун ёслолоос хүрт хэмээн Есүс Христ зарлиглав.                     | б. Лук 2:10–12    |
| 3. ____ “Зүдэж зүтгэгсэд хийгээд хүнд ачаа үүрсэн бүгд ээ, Над дээр ир. Би та нарыг амраая.” | в. Лук 22:19–20   |
|  | г. Иохан 3:5      |
|  | д. Иохан 3:16     |

## Судрын түлхүүр үг хэллэг

4–6-р асуултын хувьд, төгс эзэмших сургаалын судрын түлхүүр үг хэллэгийн дутуу орхисон үгсийг нөхөж бич. Үнэлгээний шалгалтын энэ хэсэгт судраа ашиглаж болохгүй.

- Есүс “Би \_\_\_\_\_ чамд тэнгэрийн \_\_\_\_\_ хаанчлалын түлхүүрийг өгнө \_\_\_\_\_” хэмээн хэлэв. (Матай 16:15–19)
- “Өнөөдөр, Давидын \_\_\_\_\_ хотод Аврагч Эзэн Христ \_\_\_\_\_ та нарын төлөө мэндэллээ \_\_\_\_\_.” (Лук 2:10–12)
- “Учир нь \_\_\_\_\_ сүнсэнд \_\_\_\_\_ та нарын харж \_\_\_\_\_ байгаа Над шиг яс, мах байдаггүй юм.” (Лук 24:36–39)

Та судраа үнэлгээний шалгалтын үлдсэн хэсэгт ашиглаж болно.

7–9-р асуултын хувьд, дараах нөхцөл байдалд орсон хүнд туслах төгс эзэмших сургаалын судрын нэг эсвэл хэд хэдэн хэсгийг тодорхойл.

7. Таныг номлогчидтой хамт байхад нэг хүн танаас үнэхээр баптисм хүртэх хэрэгтэй юү эсвэл зүгээр л зүрх сэтгэлдээ Есүс Христийг хүлээн зөвшөөрч болох уу? гэж асуув.	
8. Ням гаргийн ангид тойргийн тань нэг гишүүн Сүмд заадаг сургаал Бурханаас ирсэн гэдгийг хэрхэн мэдэж болох талаар асуув.	
9. Нэгэн хүн бид хэрхэн Есүс Христийн илүү сайн шавь болж чадах талаарх гэр бүлийн үдшийн хичээлээ бэлдэж байна.	

10–11-р асуултын хувьд, сүнслэг мэдлэг олж авах зарчмуудыг ашиглах мэдлэг, чадвараа харуул.

10. Сүнслэг мэдлэг олж авах дараах гурван зарчмын талаар ямар ч мэдлэггүй хүнд та тэдгээрийг хэрхэн тайлбарлах байсан бэ?

а. Итгэлээр үйлдэх

б. Утга санаа болон асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судлах

в. Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүн ойлголттой болохыг эрэлхийлэх

11. Танд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр өөрийг нь хайрладаг, өөртэй нь харилцахыг хүсдэг гэдэгт итгэж чаддаггүй нэг найз байдаг. Дараах асуултуудад хариул.

а. Итгэлээр үйлдэхийн тулд та түүнийг юу хийхэд урих байсан бэ?

б. Та түүнд нөхцөл байдлаа мөнхийн талаас нь шинжлэн судлахад хэрхэн тусалж чадах вэ?

в. Төгс эзэмших сургаалын судрын хэсгүүд бол тэнгэрээс томилогдсон эх сурвалжийн нэгэн жишээ юм. Та түүнтэй төгс эзэмших сургаалын судрын ямар хэсгийг хуваалцах вэ? Яагаад?

12. Таны өнөөг хүртэл судалсан төгс эзэмших сургаалын 11 хэсгээс аль нь танд хамгийн их нөлөөлсөн бэ? Судрын уг хэсэг танд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын талаар юу заадаг вэ?